



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын 3.4.1.9, “Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015” хөтөлбөрийн 2.2.1, тус газрын Дүрмийн 2.3, 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын түүхэн дурсгалт газар, үзэсгэлэнт байгаль, томоохон үйлчилгээний газруудыг танилцуулсан нэг минутын видео сурталчилгаа бэлтгэх, гэрэл зургийн сан үүсгэх ажлыг “Онъс Медиа” ХХК-иар гүйцэтгүүлсүгэй.

2. “Онъс Медиа” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн технологийн инженер /Д.Монголхүү/-т даалгасугай.

3. Гэрээт ажлын хөлс болох 2.500.000 /хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА